

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023
оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 14:00
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Албаны дарга

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Экологийн цагдаагийн алба

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-1

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж-6

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас батлан гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдолтой бодлогын болон захиргааны үйл ажиллагаанд хамаарах баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, албан даалгавар, тушаалын хэрэгжилтийг хангаж, бүтцийн нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, гүйцэтгэх ажлын тоо бүртгэл хөтлөх, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэхэд дүн шинжилгээний ажлаар дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, хяналт тавин, байгууллага, алба хаагч, бусад ажиллагдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг албаны хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

2. Хууль тогтоомжийн хүрээнд Экологийн цагдаагийн албаны үндсэн чиг үүрэг, бодлого чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
3. Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын шугамаар тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэх ажлын болон мөрдөн шалгах нууц ажиллагааны ажлын явц, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлох;
4. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын гүйцэтгэх ажлын болон бусад шаардлагатай мэдээллээр хангаж, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Экологийн цагдаагийн албаны үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник технологийн ололтыг нэвтрүүлэх, гадаад улс орны төрөл, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг судлах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээг авч, биелэлт, үр дүнг тооцох;
6. Төрийн болон албаны нууцыг хамгаалж, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, алба хаагч, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж, тэдний мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшнийг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн байдлыг сайжруулах зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, шийдвэрлэх;
7. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хууль, тогтоол, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх;
8. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас батлан гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдолтой бодлогын болон захиргааны үйл ажиллагаанд хамаарах баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, албан даалгавар, тушаалын хэрэгжилтийг хангаж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд нь гарган холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p> <p>1.2. Цагдаагийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлан гүйцэтгэлд хяналт тавих;</p> <p>1.3. Албаны үйл ажиллагаанд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 110/-ын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p>	<p>Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогын хэрэгжилт хангагдсан байна.</p>	X, Ш
			X, Ш
			X, Ш

	<p>ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ажлыг холбогдох газар. хэлтсээр гүйцэтгүүлж, хяналт тавьж үр дүнг тооцох.</p> <p>1.4.Байгууллагын ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>1.4.Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>1.5.Алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар ханган, хяналт тавьж, ажлын үр дүнг зохих журмын дагуу сар бүр үнэлж дүгнэн холбогдох арга хэмжээг авах;</p>		X, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Цагдаагийн байгууллагаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, үр дүнг хариуцах;</p> <p>2.2.Хяналтад авч үнэлгээ, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн хэрэгжилтийг хангах удирдан зохион байгуулах;</p> <p>2.3.Цагдаагийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;</p> <p>2.4.Хариуцсан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, биелэлтийг дүгнэх;</p> <p>2.5.Гүйцэтгэх ажлын нөхцөл байдалд улирал тутам үнэлэлт, дүгнэлт өгч, улсын хэмжээнд албанаас хэрэгжүүлэх бодлого, чиглэл, үндсэн чиг үүргийг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	Дэвшүүлсэн зорилтууд хэрэгжиж, албаны үйл ажиллагаа, ажлын дүн, гэмт хэргийн болон гүйцэтгэх ажлын нөхцөл байдал зөв үнэлэгдэж, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарна.	X, Ш Х, Ш Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хариуцах;</p> <p>3.2.Албанад хуулиар харьяалуулсан гэмт хэргийн талаар авагдсан мэдээ, мэдээллийг шалгаж, баримтжуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэх ажлын болон мөрдэн шалгах нууц ажиллагааны явц, үр дунд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлох;</p> <p>3.3.Хуулиар харьяалуулсан гэмт</p>	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангаж, гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын шугамаар тэмцэх ажилд ахиц гарна.	X, Ш Х, Ш

	<p>хэрэгтэй тэмцэхэд мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, эрх бүхий байгууллага, албан тушаалтыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>3.4.Гүйцэтгэх ажлын зорилго, зорилтыг хангахад чиглэсэн гүйцэтгэх ажлын хүч, хэрэгслийн сүлжээг зохион байгуулах, нууцлал, аюулгүй байдлыг хангах, цаг үеийн хэрэгцээ шаардлага хангасан мэдээ, мэдээлэл олоход чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч, хяналт тавьж, цагдаагийн төв байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;</p> <p>3.5.Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын зааврын 4.4-т заасан ажлыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлт, үр дүнг тооцох;</p> <p>3.6.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоо чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, биелэлт, үр дүнг тооцож, хяналт тавих;</p> <p>3.7.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.7 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааны журмыг мөрдөж, хяналт тавьж, үр дүнг тооцох.</p>	X, Ш Х, Ш Х, Ш Х, Ш Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.19 дэх хэсэгт заасан “Цагдаагийн байгууллага гүйцэтгэх ажлын тоо бүртгэл” хөтлөх заалтын хүрээнд гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллийг бүртгэх, үнэлэх, танилцуулах түүний шийдвэрлэлт, туслах хүч, хэргийн бүртгэл, хөдөлгөөн, нууцлал, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих;</p> <p>4.2.Гүйцэтгэх ажлын болон бусад төрлийн мэдээллийн сан бүрдүүлэх, нээлттэй, хаалттай, нууц эх сурвалжийн мэдээг нэгтгэн боловсруулж, дун шинжилгээ хийлгэн, цаг үеийн болон бусад шаардлагатай мэдээллээр Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг хангах;</p> <p>4.3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албыг мэдээллээр хангах ажлын хүрээнд зохион байгуулсан ажил, нууц эх сурвалжийн мэдээнд дун шинжилгээ хийж,</p>	X ҮАБЗ, Цагдаагийн байгууллагын удирдлагыг цаг үеийн шинжтэй мэдээллээр шуурхай хангаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлсэн байна. Х, Ш Х, Ш

	<p>Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад хүргүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>4.4.Гэмт хэрэг, гүйцэтгэх ажлын нөхцөл байдлын талаар хуулиар эрх олгогдсон тэр, захиргааны байгууллагын удирдлагад мэдээлэл, танилцуулга хүргүүлж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>4.5.Танилцуулагдсан мэдээллийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас өгсөн шийдвэр, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох газар, хэлтэс, тасаг, алба хаагчаар гүйцэтгүүлэн биелэлт, үр дүнд хяналт тавих.</p>		X, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	<p>5.1.Албаны үйл ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээний ажил, үйл ажиллагаанд шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгө, төсвийн судалгааг холбогдох албан тушаалтнаар гүйцэтгүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлах ажлыг зохион байгуулах;</p> <p>5.2.Гадаад улсын ижил төрөл мэргэжлийн байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны туршлага судлах, алба хаагчдыг гадаад улсад сургаж, мэргэшүүлэх ажлын саналыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх.</p>	Албаны болон алба хаагчдын ажил, мэргэжлийн ур чадвар сайжирч, хамтын ажиллагаанд ахиц гарна	X, Ш
6 дугаар зорилтын хүрээнд	<p>6.1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 939, 940/-ын хүрээнд алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, үр чадварын түвшнийг дээшлүүлэх сургалт, соён гэгээрүүлэх ажил, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулахад удирдлагаар ханган биелэлт үр дүнг тооцох;</p> <p>6.2.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 100, 101, 112, 113/-ын хүрээнд цагдаагийн байгууллагын чиг үүрэг, дотоод албаны дүрмийг хэрэгжүүлэх, албаны шалгалт явуулах, дотоод аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахад удирдлагаар ханган биелэлт үр дүнг тооцох;</p> <p>6.3.Хууль тогтоомж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу хүний нөөцэд авах, албан тушаалд томилох, чөлөөлөх, албан</p>	Алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ажлын үр дүн дээшилнэ.	X, Ш

	<p>тушаал бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах саналыг Цагдаагийн ерөнхий газарт хургуулж, шийдвэрлүүлэх;</p> <p>6.4.Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан өөрийн эрх хэмжээний хүрээнд зохих шийдвэрийг гаргах, холбогдох зарим асуудлыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад уламжлан шийдвэрлүүлэх;</p> <p>6.5.Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>6.6.Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зорчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үр дүнг тооцох;</p> <p>6.7.Алба хаагчдын сахилга, хариуцлага, үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх, холбогдох байгууллага, алба хаагчид шилжүүлэх;</p> <p>6.8..Алба хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч, өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, хүсэлтийг удирдах дээд шатны албан тушаалтанд уламжлах.</p>	X, Ш	
7 дугаар зорилтын хүрээнд	<p>7.1 Төсвийн тухай хуулийн дагуу тус албанд хуваарилагдах төсвийг шилжүүлэн авч, санхүүгийн тайлан тэнцэл, бусад холбогдох орлого, зарлагын гүйлгээ, хөрөнгө материалын шилжилт хөдөлгөөнийг цаг тухай бүрд хийлгэж, хяналт тавих;</p> <p>7.2.Санхүүгийн ил тод байдлыг хангах.</p>	Албаны үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдана.	X, Ш
8 дугаар зорилтын хүрээнд	<p>8.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;</p> <p>8.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн,” Цагдаагийн алба</p>	Цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.	Г

	хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 8.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.		Г
--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	---

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хамгаалал /1032/		
Мэргэшил	-Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх. -Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс газрын дарга түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	-Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; -Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.	
	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; -Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах.	
	Асуудал шийдвэрлэх	-Хуульд нийцсэн шийдвэр гаргах; -Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; -Аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах; -Албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах; -Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх.	
	Манлайлах	-Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.	
	Бусад	-Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

-Цагдаагийн ерөнхий газрын дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоогоор.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл
----------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023. 12. 27

Дугаар: 8/403

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр



ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:

.....
.....
.....

2023 оны дугаар сарын-ны өдөр